

БАТЛАВ

ЗАХИРАЛ

Т.АЗБАЯР



Огноо: 2019-01-04

**ЧАНДМАНЬ-ИЛЧ ХХК-ИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДЛАГАТАЙ ШАТАХ, ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

/Тендер шалгаруулалт/ *Tender.gov.mn*

гэрээний нэр, дугаар: *ЧИНТШ-2019/01*

Төсөв өртөг:
268,606.400

САЙНШАНД ХОТ

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:2019-01-04

Тендер шалгаруулалтын нэр: **Чандмань-илч ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай шатах, тослох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар:**ЧИНТШ-2019/01**

“Чандмань-Илч” ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [**Чандмань-илч ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай шатах, тослох материал нийлүүлэх**] тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцогч нь: тендерийн баримт бичгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрж цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 МБ, нэг файлын хэмжээ 15 МБ байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараахь шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:**400,0 сая төгрөг**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:**1 жил**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **/шаардлагатай /1,2,3-р багийн нутаг дэвсгэрт шатахуун худалдан борлуулах түгээх зөвшөөрөлтэй байх/**

Тендерийн хамт **4,0 сая** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийн баталгаа хүчинтэй хугацаа **2019-03-18** өдөр

Тендерийг **2019 оны 02-р сарын 04-ний өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцор хүсэлтэй тендерт оролцогчдыг **2019 оны 02 дугаар сарын 04-ний өдөр**-ны өдрийн **10 цаг 30 минут**-т нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Төлбөр хийх хэлбэр: **Дансаар тушаана**

Банкны нэр: **ХААН банк**

Дансны дугаар: **5360001473**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь, Сайншанд, 2-рбаг, Энхтайвны гудамж, Чандмань-Илч ХХК-ын удирлагын байр, 3-р давхар, 308 тоот утас-99121345

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

ГАРЧИГ

- А. Ерөнхий зүйл**
1. Тендерийн цар хүрээ
 2. Санхүүжилтийн эх үүсвэр
 3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл
 4. Эрх бүхий тендерт оролцогч
 5. Эрх бүхий бараа
- Б. Тендерийн баримт бичиг**
6. Тендерийн баримт бичгийн агуулга
 7. Тендерийн баримт бичгийг тодруулах
 8. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах
- В. Тендер бэлтгэх**
9. Тендер шалгаруулалтад оролцох зардал
 10. Тендерийн хэл
 11. Тендерийн иж бүрдэл
 12. Тендерийн маягт болон үнийн хуваарь
 13. Хувилбарт тендер
 14. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт
 15. Тендерийн валют
 16. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт
 17. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт
 18. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт
 19. Тендер хүчинтэй байх хугацаа
 20. Тендерийн баталгаа
 21. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах
- Г. Тендер ирүүлэх**
22. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх
 23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
 24. Хугацаа хоцорсон тендер
 25. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх
 26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах
- Д. Тендерийг нээх, үнэлэх**
27. Тендерийг нээх
 28. Нууцлал
 29. Тендерийн тодруулга
 30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцэх эсэхийг тогтоох
 31. Алдааг залруулах
 32. Нэг валютэд хөрвүүлэх
 33. Тендерийг үнэлэх, харьцуулах
 34. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах
 35. Аливаа тендерийг сонгох, эсвэл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх
- Е. Гэрээ байгуулах эрх олгох**
36. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур
 37. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 38. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|---|---|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.</p> <p>1.3. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | <p>2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.</p> |
| 3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл | <p>3.1. Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцожгэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.</p> |
| 4. Эрх бүхий тендерт оролцогч | <p>4.1. Тендерийн урилга нь сонирхосон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьяалалтай байж болно.</p> <p>4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:</p> <p>4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;</p> <p>4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;</p> |

4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;

4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;

4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;

4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;

4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;

4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)

4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

5. Эрх бүхий бараа

5.1. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТООЗ-ны 1.1-д дурдсан барааг хүлээн авснаар төлнө.

5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан барааны гарал үүсэл

гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

6. Тендерийн баримт бичгийн агуулга

6.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:

I ХЭСЭГ

- Бүлэг 1. Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
Бүлэг 3 Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт
Бүлэг 4. Тендер шалгаруулалтын маягт
- Тендерийн маягт
 - Үнийн хуваарь
 - Тендерийн баталгааны маягт

II ХЭСЭГ

- Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт

III ХЭСЭГ

- Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл
Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл
Бүлэг 8. Гэрээний маягт
- Гэрээний маягт
 - Гүйцэтгэлийн баталгааны маягт
 - Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендерийн урилга

6.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

6.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

7. Тендерийн баримт бичгийг тодруулах

7.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн телекс болон факсыгхамруулна)-гоор ТШӨХ-дзаасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн

авсан хүсэлтэд хариу өгнө.

Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

- 8. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**
- 7.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахшаардлагатай гэж үзвэл энэхүү ТООЗ-ны 9дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.
- 8.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 8.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 8.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийгбэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 9. Тендер шалгаруулал -тад оролцох зардал**
- 9.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
- 10. Тендерийн хэл**
- 10.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн барим бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.
- 10.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТООЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийгхянан үзэх, үнэлэхэд харгалзана.
- 11. Тендерийн иж бүрдэл**
- 11.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) ТООЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу

- бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваарь;
- (б) захиалагч шаардсан бол ТООЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;
 - (в) тендерт оролцогчийг төлөөлж ТООЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;
 - (г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
 - (д) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
 - (е) нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;
- (ё) ТШӨХ-д шаардсан ТООЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэхбусад материал.

12. Тендерийн маягт болон үнийн хуваарь

- 12.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.
- 12.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.

13. Хувилбарт тендер

- 13.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.

14. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт

- 14.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.
- 14.2. Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.
- 14.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.
- 14.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.
- 14.5. Олон улсын худалдааны EXW, CIF болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон

улсын худалдааны танхимаас эрхэлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийнхувилбарыг удирдлага болгоно.

14.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

14.7. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.

14.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТООЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаасүзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.

14.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:

(а) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:

1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;

2. импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;

3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;

1. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

2. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(г) Барааны Техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний талаарх шаардлагад тодорхойлсон Дагалдах үйлчилгээний хувьд:

Гэрээ байгуулах эрх олгогдсоноор Дагалдах үйлчилгээнд ногдох Худалдан авагч орны гаалийн, худалдааны болон бусад адилтгах албан татварыг тооцож

- (1) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн дотоодын валютаар илэрхийлэгдэх зардлын өртөг;
- (2) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн гадаадын валютаар илэрхийлэгдэх зардлын өртгийг тус тус харуулна.

14.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

14.11. ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

14.12. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

15. Тендерийн валют

15.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.

16. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт

16.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,
- (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
- (в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.

17. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт

17.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

- (а) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4

дүгээр бүлгийнмаягтаас тохирох маягтыг ашиглан ирүүлнэ;

- (б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
- (в) гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
- (г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
- (д) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
- (е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
- (ё) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
- (ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.

17.2. Тендерт оролцогч ТООЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

- (а) сүүлийн 1 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;
- (б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;
- (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
- (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.

(д) сүүлийнТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

18. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт

18.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:

(а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;

(б) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;

(в) захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ.

19. Тендер хүчинтэй байх хугацаа

19.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.

20. Тендерийн баталгаа

20.1. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.

20.2. Тендер шалгаруулалт олон багцтай болнэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.

20.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.

20.4. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэг дэх маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

20.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.

20.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

20.7. Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

- 20.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт багтаан хүчингүй болгоно.
- 20.9. Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг ТООЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТООЗ-ны 42 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.
- 20.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:
- (а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
 - (б) тендерт оролцогч 32.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТООЗ-ын 38.2-т заасан нөхцөл үүссэн бол;
 - (в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:
 - (1) ТООЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;
 - (2) ТООЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй.

21. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

- 21.1. Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэгбүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.
- 21.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.
- 21.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

22. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх

Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрж цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 МБ, нэг файлын хэмжээ 15 МБ байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

22.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.

22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжилнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТООЗ-ны 23.3, 23.4 –т заасныг баримтална.

22.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- (а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;
- (б) ТШӨХ-д заасан хаягаар ТООЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах;
- (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТООЗ-ны 1.1 болон ТШӨХ-д тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;
- (г) ТООЗ-ны 28.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.

22.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.

22.5. ТООЗ-ны 23.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.

23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

23.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

23.2. Захиалагч ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

24. Хугацаа хоцорсон тендер

24.1. Захиалагч ТООЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.

- 25. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**
- 25.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.
- 26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**
- 26.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.
- 26.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 22, 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.
- 26.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.
- 26.4. ГОӨЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.
- 26.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

- 27. Тендерийг нээх**
- 27.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.
- 27.2. Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. “ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” бичиглэл бүхий дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана.
- 27.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон

захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

27.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:

- (а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;
- (б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт;
- (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

28. Нууцлах

28.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

28.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.

28.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоозөвхөн бичгээр харилцана.

29. Тендерийг тодруулах

29.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна. Гэхдээ 31 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

30.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараахь шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:

- (а) ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
- (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;
- (в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагыг хангасан тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;
- (г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;
- (д) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод

шаардлагыг хангасан эсэх.

30.2. ТООЗ-ны 31.1 дэх заалтын (а) - (д)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

30.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзол, тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:

- (а) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

30.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

31. Алдааг залруулах

31.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоондунг засварлах;
- (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;
- (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

31.2. Захиалагч, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнэнд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

32. Нэг валютад хөрвүүлэх

32.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТООЗ-ны 16 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

**33. Тендерийг
үнэлэх,
харьцуулах**

- 33.1. Захиалагч зөвхөн 31 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.
- 33.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:
- (а) ТООЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;
 - (б) ТООЗ-ны 31.3 дугаар зүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх;
 - (в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;
 - (г) захиалагч энэ тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг түүнд холбогдох аргачлалын дагуу тооцон мөнгөөр илэрхийлж, түүнийг тендерийн үнэд нэмж тооцох;
- 33.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 35.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.

**34. Тендерт
оролцогчийн
чадварыг
дахин
магадлах**

- 34.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 34.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТООЗ-ны 18.2-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 34.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

**35. Аливаа
тендерийг
сонгох, эсхүл
тендерүүдээс
татгалзах
захиалагчийн
н эрх**

- 35.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

**36. Гэрээ
байгуулах
эрх олгох
шалгуур**

36.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

36.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.

**37. Гэрээ
байгуулах
эрх олгох
мэдэгдэл**

37.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээ гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.

37.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

37.3. Захиалагч Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn цахим хуудсанд тендерийн нэр болон багцын дугаарыг дараахь мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ. Үүнд:

- 1) тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
- 2) тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
- 3) нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
- 4) тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
- 5) тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.

37.4. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

37.5. Тендер нь шалгарсан оролцогч ТООЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа гаргаж, гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсэн даруй захиалагч ТООЗ-ны 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож, энэ тухайг шалгараагүй бусад тендерт оролцогчид мэдэгдэнэ.

**38. Захиалагч
гэрээ
байгуулах
эрх олгох үед
тоо хэмжээг
өөрчлөх**

38.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.

**39. Гэрээнд
гарын үсэг
зурах**

39.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

39.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаантүүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

39.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТООЗ-ны 39.4-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч нь: <i>Дорноговь аймгийн Чандмань-Илч ХХК</i>
ТООЗ 1.1a	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <i>Чандмань-Илч ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажилгаанд шаардлагатай шатахуун, тослох материал нийлүүлэх ЧИНТШ-2019/01</i>
ТООЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Нэг багц: Чандмань-илч ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажилгаанд шаардлагатай шатах, тослох материал нийлүүлэх ЧИНТШ-2018/01</i>
ТООЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Өөрийн үйл ажиллагааны орлогоос Шатах, тослох материал 268,606,400 төгрөг</i>
	Б. Тендерийн баримт бичиг
ТООЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <i>[tender.gov.mn цахим хаяг болон Дорноговь, Сайншанд, 2-р баг, Эрх чөлөөний гудамж, Чандмань-Илч ХХК-ын удирдлагын байр, 3-р давхар, 308 тоот, утас-99121345]</i>
ТООЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.
	В. Тендер бэлтгэх
ТООЗ 11.1	Тендерийн хэл нь Монгол хэл байна
ТООЗ 12.1	Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг дор дурьдсан хэсэг, бүлэгт заасан дараалалд нийцсэн иж бүрдэл баримт бичиг болгон бэлтгэх буюу шаардлагатай бол ТООЗ-ийн 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтийг тусгасан байна. Үүнд: 1.ХЭСЭГ Бүлэг 1.Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу бэлтгэсэн баримт бичиг, нотлох баримт

	<p>Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, түүнд заасан баримт бичиг, нотлох баримт</p> <p>Бүлэг 3. Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуурт хамаарах дараах баримт бичгийг ирүүлэх. Үүнд: -ТООЗ-ны 12 дугаар зүйлийн “ё”-д заасан нэмэлт материал, -тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримт -ТООЗ-ын 18 дугаар зүйлийн 18.1-18.4-д заасан нотлох баримтууд -Тендерт оролцогчийг төлөөлж ТООЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл -тендерт оролцогчийг тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд</p> <p>Бүлэг 4. Тендер шалгаруулалтын үнэлгээнд хамаарах дараах баримтыг тендерийн багц тус бүрд ирүүлэх.Үүнд: -Тендерийн маягт - Үнийн хуваарь -Тендерийн баталгаа -дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн нэр, өртгийг дотоод валютээр илэрхийлж ирүүлнэ</p> <p style="text-align: center;">II. ХЭСЭГ</p> <p>Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага болон техникийн тодорхойлолтыг хангах талаар тендерт оролцогчийн санал, нотлох баримтыг тендерийн багцаар гаргана. Үүнд</p> <p>-санал болгосон бараа нь захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолт болон стандартад нийцэхийг зүйл заалт нэг бүрээр нотлон харуулсан тайлбар, нотлох баримтыг бэлтгэж ирүүлэх</p> <p>барааны техникийн тодорхойлолт, ашиглалтын заавар, барааны гарал үүсэл, чанарын сертификат, үйлдвэрлэгч нийлүүлэгчийн зөвшөөрлийг ирүүлнэ.</p> <p style="text-align: center;">III. ХЭСЭГ</p> <p>Бүлэг 6. Гэрээний ерөнхий, тусгай нөхцөлийг зөвшөөрөх эсэх санал, шийдвэрийг багц тус бүрд ирүүлэх</p>
<p>ТООЗ 12.1 (ё)</p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн аль нэг жилд нь санал болгож буй багцын үнийн дүнгийн 100 хувиас багагүй хэмжээний борлуулалтын орлоготой байсныг нотлох баримт бичиг /санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт/ 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас татсан хуулбарыг наториатаар батлуулж ирүүлнэ 3. Тухайн бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхэд үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрлийн хуулбарыг наториатаар батлуулж ирүүлнэ. 4. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн нөхцөл бүхий тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзана.
<p>ТООЗ 14.1</p>	<p>Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”</p>

ТӨӨЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар “Incoterms 2000”
ТӨӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)	Бараа хүргэгдэх газар: Дорноговь, Сайншанд сумын төв дэх нийлүүлэгчийн ШТС-ын түгээгүүрээс “Чандмань-Илч” ХХК-ийн авто машинуудад
ТӨӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулна” Зөвхөн тухайн барааны зах зээлийн нэгж үнэ гэрээнд заасан үнээс 15 хувь түүнээс дээш хувиар буурсан тохиолдолд захиалагч, нийлүүлэгч харилцан тохиролцож барааны нэгж үнийг бууруулах өөрчлөлтийг хийнэ. Барааны үнэд үүнээс өөр өөрчлөлт хийхийг хориглож энэ заалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют: [Төгрөг байна.]
ТӨӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгч, борлуулагчийн зөвшөөрөл “шаардлагатай”
ТӨӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: [1 жил]Аудитын дүгнэлтийн хамт.
ТӨӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: шаардлагагүй
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “шаардлагагүй”
ТӨӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: 400,0 сая
ТӨӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: [1 жил].
ТӨӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: Дорноговь, Сайншанд сумын 1, 2, 3-р багийн нутаг дэвсгэрт өөрийн ШТС-тай байх
ТӨӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: шаардлагагүй
ТӨӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: [шаардлагагүй]
ТӨӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцохгүй”
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 21.1	Тендерийн баталгааны үнийн дүн: [4 сая төгрөг] Хүчинтэй байх хугацаа: 2019 он 03 сар 18 өдөр

ТӨӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <i>[Нэг]</i>
	Г. Тендер ирүүлэх
ТӨӨЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: tender.gov.mn цахимаар ирүүлэх Байгууллагын хаяг: <i>2-р баг, Эрх чөлөөний гудамж, Чандмань-Илч ХХК-ын удирлагын байр,</i> Давхар болон өрөөний дугаар: <i>3-р давхар, 308 тоот,</i> Аймаг, хот: <i>Дорноговь аймаг, Сайншанд сум</i> Улс: <i>“Монгол Улс”</i>
ТӨӨЗ 23.3 (в)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: <i>Чандмань-илч ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажилгаанд шаардлагатай шатах, тослох материал нийлүүлэх ЧИНТШ-2019/01</i>
ТӨӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <i>[он, сар, өдрийг оруул. Жишээ нь: 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдөр]</i> Цаг: <i>10 цаг 00 минут</i>
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТӨӨЗ 28.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <i>2-рбаг, Энхтайвны гудамж, Чандмань-Илч ХХК-ын удирлагын байр,</i> Давхар болон өрөөний дугаар: <i>3-р давхар, 308 тоот өрөө,</i> Аймаг, хот: <i>Дорноговь аймаг, Сайншанд сум</i> Улс: <i>“Монгол Улс”</i> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>2019 оны 02 дугаар сарын 04-ний өдөр</i> Цаг: <i>10 цаг 30 минут</i>
	Е. Гэрээ байгуулах эрх олгох
ТӨӨЗ 40.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь:

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэрийг оруул], энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн [бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]-г [тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш [тоо] хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.
3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт [үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах] [Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул] үзүүлнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

3. ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар *[Банкны нэр]* (цаашид “Банк” гэх) нь *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт *[мөнгөн дүн]*-ийн¹ төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь *[огноог оруул]* өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

¹ Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Баталгааны мөнгөн дүн нь ТООЗ-ны 21.1-д заасантай ижил байна.

Огноог оруулахдаа ТООЗ-ны 21.3-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягтыг бөглүүлсэн байна.Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна.ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: [тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]

НТШ-ын дугаар: [оруул:тендер шалгаруулалтын дугаар]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Бид, [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]-д байршилтай [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр] нь[оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд, үүгээр [оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр] компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан [оруул: барааны нэр ба товч тодорхойлолт], барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна. Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Санхүүгийн чадавхи

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТООЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө. Татварын албанд тушаасан (захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

Банк	Банкны нэр	
	Банкны хаяг	
	Утас	Холбоо барих ажилтны нэр, албан тушаал
	Факс	Телекс

Сүүлийн (Нэг) хүртэлх жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монгол банкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

Санхүүгийн мэдээлэл /сая/	Сүүлийн (нэг) хүртэлх жилийн хугацаанд					Төлөвлөсөн: Дараагийн 1 жилийн хугацаанд	
	5	4	3	2	1	1	2
1. Нийт хөрөнгө							
2. Эргэлтийн хөрөнгө							
3. Нийт өглөг							
4. Эргэлтийн өглөг							
5. Татварын өмнөх ашиг							
6. Татварын дараах ашиг							

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТООЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр	Дүн
1.	
2.	
3.	
4.	

ТООЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендер оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хуулбарыг хавсаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

АГУУЛГА

1. Барааны нэр төрлийн жагсаалт болон нийлүүлэлтийн хуваарь
2. Техникийн тодорхойлолт

1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хуртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Дизель түлш	80,000	литр	Сайншанд сумын төв дэх нийлүүлэгчийн ШТС	2019 оны 2-р сарын 14	2020 оны 2-р сарын 14	
2	Бензин А-80	12000	литр	Сайншанд сумын төв дэх нийлүүлэгчийн ШТС	2019 оны 2-р сарын 14	2020 оны 2-р сарын 14	
3	Бензин А-92	8200	литр	Сайншанд сумын төв дэх нийлүүлэгчийн ШТС	2019 оны 2-р сарын 14	2020 оны 2-р сарын 14	
4	Тослох материал			Сайншанд сумын төв дэх нийлүүлэгчийн ШТС	2019 оны 2-р сарын 14	2020 оны 2-р сарын 14	

1. Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог. Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлтэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана. Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй. Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө. Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна. Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана. Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендерт оролцогчдод өгнө. Үүнд мөн тендерт оролцогч зураг болон загварыг тендертэй хамт, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад захиалагчид урьдчилан хянуулах зорилгоор ирүүлэхээр зааж болно. Хэрвээ захиалагч техникийн тодорхойлолтын хураангуйг гаргуулахаар бол дараах хүснэгтийг ашиглан шаардлагатай мэдээллийг тусгаж өгнө. Тендерт оролцогч санал болгож буй бараа, үйлчилгээ нь уг шаардлагад нийцэж байгаа эсэхийг ижил хүснэгтээр харуулна.

2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТУУД

1.Шатахуун,шатах тослох материал”-нд тавигдах техникийн ерөнхий шаардлага.

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардалга	Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> • МУ-ын MNS 216:2006,MNS217:2006 стандартанд нийцсэн байх МУ-ын MNS4628:98,MNS4633-98 стандартын шаардлагахангасан ШТСтанцтай байх • Эрүүл ахуйн шаардлага хангасан байх • Тээвэрлэлт, Хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. • Шинжилгээний лабораторийн итгэмжлэлтэй байх • Чанарын баталгааг хангасан байх • Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтанд тусгаж өгсөн байх • Бусад 	

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ХУРААНГУЙ

Барааны нэр:

№	Бараа болон холбогдох үйлчилгээний нэрс	Техникийн тодорхойлолт болон стандарт	Нийлүүлэгчийн санал болгосон барааны үзүүлэлт
1	Октан	ГОСТ-8826	92,0
2	15С дахь хувийн жин	MNS 0481:88	0,725-0,78
3	Найрлагын бүрэлдэхүүн	MNSISO3405:2000	
	Буцалж эхлэх температур / багагүй/	MNSISO3405:2000	Нормгүй
	10%нэрэгдэх температур /ихгүй/	MNSISO3405:2000	70С
	50% нэрэгдэх температур /ихгүй/	MNSISO3405:2000	115С
	90% нэрэгдэх температур /ихгүй/	MNSISO3405:2000	185С
	Буцалж дуусах температур /ихгүй/	MNSISO3405:2000	215С
	Үлдэгдэл/ихгүй/	MNSISO3405:2000	2,0%
	Үлдэгдэл ба хорогдол/ихгүй/	MNSISO3405:2000	4,0%
4	Ханасан уурын даралт	MNS3626:2010	35-79,9 К ПА
5	100см3 дэх бодит давирхайн агууламж/ ихгүй/	MNS0477:1996	5,0
6	Зэс хавтгай туршилт	MNS0326:2005	Тэсвэртэй
7	Усанд уусдаг хүчил шүлт	MNS0324:2005	байхгүй
8	Усны хэмжээ	MNS0332:96	байхгүй
9	Механик хольцын хэмжээ	MNS3697:1984	байхгүй
10	Өнгө	MNS2049:2000	Тунгалаг

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх **3. Шалгалт, туршилт** барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

4 Дараахи нэмэлт шалгуурыг заавал хангасан байна.

- ИС эсвэл шатахууны цахим карттай байх ба худалдан авалтын цахим тайлан харах нөхцлийг бүрдүүлсэн байна.
- Сайншанд сумын 1, 2, 3-р багийн нутаг дэвсгэрт 24 цагаар ажилладаг өөрийн шатахуун түгээх станцтай байна.
- Ажил, технологийн онцлогоос хамаарч баталгаат саваар шатахуун авах нөхцлийг шийдвэрлэсэн байх
- Хөнгөлөлт урамшуулалын бодлогын талаар тусгах

ГАРЧИГ

1. Нэр томъёо
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
3. Захиалгыг өөрчлөх
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Барааны гарал үүслийн улс
6. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт
7. Чанарын баталгаа, баталгаат засвар
8. Төлбөр
9. Үнэ
10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
11. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
12. Маргааныг шийдвэрлэх
13. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
14. Гэрээний үүргийг шилжүүлэх
15. Гэрээнд ашиглах хэл
16. Гарчиг
17. Үүргийн гүйцэтгэл

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Нэр томъёо** 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) “гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
 - (б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
 - (в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.
 - (г) “бусадүйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
 - (д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
 - (е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.
 - (ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.
 - (з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- 2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах** 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
- 2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
- 2.4. Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
- 3. Захиалгыг өөрчлөх** 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:

- (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
- (б) барааг хүргэх газар.
- 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 3.3. Захиалагч 3.2-г дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.
- 4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**
- 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
- 5. Барааны гарал үүслийн улс**
- 5.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
- 6. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 6.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 7. Чанарын баталгаа,**
- 7.1. Техникийн тодорхойлолтын хураангуйд заасны дагуу стандартын шаардлага хангасан байна.
- 8. Төлбөр**
- 8.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
- 8.2. Нийлүүлэгч нь дараа төлөх нөхцөлтэйгээр гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 8.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.

- 9. Үнэ** 9.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах** 10.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:
- (а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
 - (б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
 - (в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;
 - (г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.
- 11. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах** 11.1. Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй.² Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
- 11.2. Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:
- (а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
 - (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
- 12. Маргааныг** 12.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй

шийдвэрлэх	холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
	12.2. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
13. Гэрээний үүргийг шилжүүлэх	13.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
14. Гэрээнд ашиглах хэл	14.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь Монгол хэл дээр байна.
15. Гарчиг	15.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
16. Үүргийн гүйцэтгэл	16.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Төлбөр (ГЕН - 14)	14.4	Захиалагч барааны төлбөрийг нийлүүлэгчид ГТН-д заасны дагуу хийнэ: <ul style="list-style-type: none">- Захиалагч сарын худалдан авалтын төлбөрийг хэсэгчилэн урьдчилж төлнө.- Өөрийн үйл ажиллагааны орлого цуглуулалтаас хамаарч зээлээр бараа худалдан авах тохиолдолд барааг дараа төлөх нөхцөлтэйгээр худалдан авах ба барааны үнийг нэхэмжлэлийн дагуу 30 хоногийн дотор төлж барагдуулна.
2. Үнэ (ГЕН - 15)	15.1	Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд үнийг тохируулах санал гаргах эрхтэй. Үүнд: <p style="text-align: center;">Зөвхөн тухайн барааны зах зээлийн нэгж үнэ гэрээнд заасан үнээс 15 хувь түүнээс дээш хувиар буурсан тохиолдолд захиалагч, нийлүүлэгч харилцан тохиролцож барааны нэгж үнийг бууруулах өөрчлөлтийг хийнэ.</p>
3. Алданги оногдуулах (ГЕН - 17)	17.1	Алданги оногдуулах хувь: <i>Тооцохгүй</i>
4. Цахим үйлчилгээ		ИС эсвэл шатахууны цахим карттай байх ба худалдан авалтын цахим тайлан харах нөхцлийг бүрдүүлсэн байна.
5. Урамшуулал		Бэлтгэн нийлүүлэгч өөрийн компанийн маркетингийн үйлчилгээний дагуу урамшуулал үзүүлж болно. Энэ нь сонгон шалгаруулах ажиллагааны давуу тал болно.
6. Хохирлыг барагдуулах		[Тухайн барааны шинж чанарын улмаас ямар нэг алдагдлыг (жишээлбэл бүтээгдэхүүний хариуцлагатай холбогдсон) нөхөх, эсхүл үүрэг хүлээх шаардлага үүсч болзошгүй тохиолдолд энэ тухай заалтыг ГТН-д заана.]
7. Бусад нөхцлүүд		Дараахи нэмэлт шалгуурыг заавал хангасан байна. <ul style="list-style-type: none">• Сайншанд сумын 1, 2, 3-р багийн нутаг дэвсгэрт 24 цагаар ажилладаг өөрийн шатахуун түгээх станцтай байна.• Ажил, технологийн онцлогоос хамаарч баталгаат саваар шатахуун авах нөхцлийг шийдвэрлэсэн байх• Хөнгөлөлт урамшуулалын бодлогын талаар тусгах

НАЙМДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны сарын -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийнтөгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь нэр төрлийн барааг оны дугаар сарын -нээсоны дугаар сарын -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]